



АЛТАН ГАДАС ОДОНТ
“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН 2024



АГУУЛГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН-2024

1. Удирдлага, хүний нөөц	4
2. 2024 оны санхүүгийн тайлан	16
3. Техник, эдийн засгийн үзүүлэлт.....	28
4. Технологийн сахилга.....	46
5. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт	54
6. Эрчим хүч борлуулалт.....	62
7. ХАБЭА, ГАУС арга хэмжээ	70
8. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн	76
9. Чойбалсан 50 МВт-ын өргөтгөл.....	78





УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

Төлөөлөн удирдах зөвлөл:

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 100% төрийн эзэмшилд байдаг ба Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг Эрчим хүчний яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хангаж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 9 гишүүнтэй. Үүнээс Төрийн төлөөлөл 6, хараат бус 3 гишүүнтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагыг хянах үүргийн хүрээнд компанийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг тогтмол сонсож, компанийн үйл ажиллагааны онцлог, шуурхай байдлыг хангах чиглэл баримтлан Компанийн тухай хууль, компанийн дүрмийн хүрээнд сайн засаглалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд анхаарч ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд Эрчим хүчний сайдаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу 18 удаа хуралдсан бөгөөд 17 хурлыг цахимаар хуралдаж, нэг удаа компани дээр ирж хуралдсан. Нийт 53 асуудал хэлэлцэж, 31 тогтоол, 22 тэмдэглэлээр шийдвэр гаргасан



О.ХУЯГЦОГТ
ТУЗ-ийн дарга



В.ДАРХАНБААТАР
ТУЗ-ийн гишүүн



Д.ОЮУНЧИМЭГ
ТУЗ-ийн гишүүн



Б.ЭНХТӨР
ТУЗ-ийн гишүүн



С.АНАР
ТУЗ-ийн гишүүн



Б.МӨНХБААТАР
ТУЗ-ийн гишүүн



И.АЛТАНСУВД
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Г.МӨНХБАЯР
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Э.ГАНБААТАР
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Бүтэц, зохион байгуулалт, орон тоо, хүний нөөц:


2024 онд Компанийн хэмжээнд бүтэц, зохион байгуулалт, орон тоонд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр 3 удаагийн өөрчлөлт орсон.

Тайлант онд компанийн хамгаалалтыг Дотоодын цэрэг гүйцэтгэхээр шийдвэрлэсэн, 50 МВт-ын шинэ станцыг хүлээн авч, ашиглахтай холбоотойгоор хамгаалалтын алба, төслийн нэгжийг татан буулгах, шинээр орон тоо нэмэх зэргээр батлагдсан бүтэц, оронд тоонд ихээхэн хэмжээний өөрчлөлт орохын зэрэгцээ ажлын байр өөрчлөх шилжилт хөдөлгөөнүүд нилээдгүй хийгдсэн.

“ДБЭХС” ТӨХК нь ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 31 тоот тогтоолоор батлагдсан Сүхбаатар ЦТС-ний 1 салбар, Захиргаа, хүний нөөцийн, Санхүү, эдийн засгийн, Худалдан авах ажиллагааны, Хяналт аюулгүй ажиллагааны, Техникийн бодлогын, Нийтлэг үйлчилгээний, Эрчим хүч борлуулалтын гэсэн 7 хэлтэс, Үйлдвэрлэл шуурхай ажиллагааны 1 алба, Төслийн зохицуулагч, Түлш дамжуулах, Зуух, Турбин, Хими, Цахилгаан, Компьютер-дулааны хэмжүүр автоматик, Цахилгаан шугам сүлжээ, Дулааны шугам сүлжээний нийт 8 цех, нэгжийн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулах тогтоолыг мөрдөн ажиллаж байна.

Компанийн хүний нөөцийн хувьд удирдлага 10, ИТА 165, ажилтан 565 нийт 740 хүний батлагдсан орон тоотой, магистр 8, бакалавр 341, тусгай дунд 49, бүрэн дунд 324, бүрэн бус дунд боловсролтой 10 хүн байгаагаас Монгол улсын Зөвлөх инженер 8, мэргэшсэн инженер 16, мэргэшсэн нягтлан бодогч 7, мэргэшсэн төсөвчин 4 хүн ажиллаж байна.

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН БҮТЦИЙН СХЕМ



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН




Нас:

20-30 насны 139, 31-40 насны 266, 41-50 насны 225, 51-с дээш насны 79;

Ажилласан жил:

0-5 жил 286, 6-10 жил 108, 11-15 жил 119, 16-20 жил 114, 21-25 жил 39, 26-аас дээш жил 43;



2024 онд сул чөлөөтэй ажлын байрны зарыг аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар болон компанийн сайтаар 73 удаа зарлуулж, 414 ажил хайгч иргэнийг бүртгэж, сонгон шалгаруулалт явуулсан.

Тайлант онд 157 хүн ажилд шинээр орсон бөгөөд өөрийн хүсэлт, ажлын шаардлагаар албан тушаал өөрчлөгдсөн 158 хүн байна.

Мөн 69 ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос өндөр насны тэтгэвэрт 21, ажил олгогчын санаачлагаар 14, бүтцийн өөрчлөлтөөр ажлын байр хасагдсан 4, гэрээний хугацаа дууссан 5, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 24, хүүхэд асрах чөлөө авсан 1 ажилтан байна. Өмнөх онтой харьцуулсан байдал:






Сургалт хөгжил


Компанийн хэмжээнд 2024 онд нийт 37 нэр төрлийн сургалтад 124,046,800 төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 31 төрлийн сургалтад 117,852,894 төгрөг зарцуулж 95 хувийн биелэлттэй ажилласан. Давхардсан тоогоор 1690 ажилтан хамрагдсан. Өмнөх онтой харьцуулахад төлөвлөгөөний биелэлт дээшилсэн хэдий ч сургалтын төрөл буурсан нь томилолтын зардал өссөнтэй шууд хамааралтай байна.

№	Он	Сургалтын тоо	Төлөвлөгөө /сая.төг	Биелэлт /сая.төг	Хувь
1	2022 он	57	111,128,800	83,000,000	74.69%
2	2023 он	54	137,554,680	130,286,295	94.72%
3	2024 он	37	124,046,800	117,852,894	95.01%

Сургалт явагдсан байрлал



Сургалтын зардлын бүтэц




Эрчим хүчний салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг оновчтой болгох хүрээнд ЭХҮТ-ийн Сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллаж, нийт ажилтнуудын ХАБЭА-н сургалт, даралтат сав шугам хоолойтой ажиллах ажилтнуудын эрх олгох, эрх сунгах зэрэг 10 гаруй сургалтыг хамтран зохион байгууллаа.

“ДБЭХС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс аттестатчилалыг төлөвлөгөөний дагуу 2024 оны 04 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аттестатчилалд нийт 365 ажилтан хамрагдахаас 359 ажилтан хамрагдаж 98,3%-ийн ирцтэй оролцсон бөгөөд 6 ажилтан хүндэтгэх шалтгааны улмаас хамрагдаагүй байна.

Компанийн хэмжээнд аттестатчиллын дундаж үнэлгээ 71,5%-тай гарсан нь цаашид сургалтын ажлыг эрчимжүүлэх, чанар, үр дүнд анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Нэгж, хэсэг бүрийн үнэлгээний дундаж:



№	Үнэлгээ	ТДЦ	Зуухан цех	Турбин цех	Цахилгаан цех	Ком-ДХА цех	МЗХэсэг	ЦШС цех	ЭХБХ	ДШС цех	СБ ЦТС салбар	Нийт
1	85%-иас дээш буюу хангалттай сайн	0	14	3	1	0	1	2	0	7	2	30
2	60-84% буюу зэрэг хангасан	34	58	39	24	12	11	57	13	25	44	317
3	50-59% буюу хангалтгүй	3	0	2	3	0	1	1	1	1	0	12
4	НИЙТ	37	71	44	28	12	13	60	14	33	46	359

2024 онд дагалдуулан сургах багш шавийн гэрээг 123 ажилтантай байгуулсан ба үүний 105 нь хугацаандаа шалгалт өгч урамшуулал авсан. Энэ нь өмнөх оноос 3,5 дахин нэмэгдсэн байна.

“Аргон гагнуурын сургалт”-д хамрагдсан Турбин цехийн гагнуурчин Э.Отгонсүрэн, Зуухан цехийн гагнуурчин С.Болор-Эрдэнэ, ХАБ-ын мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан ХяААХ-ийн ХАБ-ын инженер Г.Энхбаяр нартай тогтвортой ажиллах гэрээ байгуулсан.






Томоохон сургалтууд:

- Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 27 дугаар зүйлийн 27.3.4 дэх заалтын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт ажилтны сургалтыг “Хэрлэн эрдэс хими” ХХК-ийн сургалтын төвийн сургагч багш Монгол улсын зөвлөх инженер Б.Шинэбаяртай хамтран 3 өдрийн хугацаанд зохион байгуулж, сургалтад нийт 567 ажилтныг хамруулсан.
- Аймгийн Политехник коллежтэй хамтран Дорнод, Сүхбаатар аймгийн сумдын 80 гаруй байцаагч, монтёруудыг цахилгаан техникийн онолын мэдлэг олгох анхан шатны сургалтад хамруулсан.
- Даралтат сав шугам хоолойг аюулгүй ашиглах эрх олгох, эрх сунгах сургалтыг “Хэрлэн эрдэс хими” ХХК-ийн сургалтын төвийн сургагч багш Монгол улсын зөвлөх инженер Б.Шинэбаяртай хамтран 3 өдрийн хугацаанд зохион байгуулж, сургалтад нийт 153 ажилтан хамруулсан.
- 50МВт-н шинэ станцад ажиллах ажилтнуудыг дадлагажуулах зорилгоор ижил төстэй тоног төхөөрөмжтэй “ТЭЦ-3” ТӨХК болон “Амгалан ДЦС”-д 35 ажилтныг 4 хоногийн хугацаанд томилолтоор ажиллуулж, 17,750,000 төгрөг зарцуулсан байна.
- Мөн “ТВЕА” ХХК-тай хамтран 50МВт-н станцад ажиллах зуух, турбин, цахилгаан цехийн нийт 47 ажилтныг 72 цагийн сумиляцийн сургалтад хамруулж, мэдлэгийн шалгалт авч ажилласан.
- ХАБЭА-н тухай хуульд заасны дагуу шинэ ажилтны сургалтыг 2024 оны 9-р сард зохион байгуулж, 111 ажилтан хамруулсан. Сургалтыг ХАБ-н инженер Г.Энхбаяр, Чадамжийн эрин академийн сургагч багш нар, Галын байцаагч С.Шижирбаатар, ХХХуулийн мэргэжилтэн Н.Одгэрэл нар хичээл зааж, мэдээлэл өгсөн.



Хөдөлмөрийн харилцаа, тушаал шийдвэр:

2024 онд Гүйцэтгэх захирлын А буюу үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 134, Б буюу хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцтэй холбоотой тушаал 638 гарсан. Өмнөх онтой харьцуулахад А тушаал 12-оор, Б тушаал 155-аар өссөн байна.



Олон нийтийн ажил:

Монгол Улсын зүүн бүсийн хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулан, хэрэглэгчдэд цахилгаан дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн түгээх ажилдаа сэтгэл зүтгэл гаргаж, мэргэжлийн өндөр түвшинд үр бүтээлтэй ажилласан амжилтыг нь үнэлэн Г.Алтанцоож даргатай Түлш дамжуулах цех, Т.Оюун даргатай Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн хамт олныг 2024 оны “ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА ХАМТ ОЛОН” -оор тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.





Компанийн техникийн болон эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, ажлын амжилт бүтээлээрээ хамт олноо хошуучлан ажилласан албан хаагчдыг шалгаруулан шагналыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан болон захирлын зөвлөлийн гишүүд гардууллаа.



№	Номинаци	Овог нэр	Алба, хэлтэс, цех	Албан тушаал
1.	Үйлчилгээний тэргүүний ажилтан	Д.Оюунцэцэг	Нийтлэг үйлчилгээний хэлтэс	Үйлчлэгч
2.	Борлуулалтын тэргүүний ажилтан	Э.Далантай	Сүхбаатар ЦТСүлжээ салбар	Байцаагч монтёр
3.	Тэргүүний жолооч	Б.Энх-Амгалан	Түлш дамжуулах цех	Бульдозерийн жолооч
4.	Тэргүүний монтёр	Д.Сүхболд	Эрчим хүч борлуулалтын хэлтэс	Техник үйлчилгээний монтёр
5.	Тэргүүний засварчин	С.Гантулга	Зуухан цех	Халах гадаргуугийн засварчин
6.	Тэргүүний машинч	Г.Гантуяа	Турбин цех	Ахлах машинч
7.	Тэргүүний оператор машинч	Ц.Цэрэндолгор	Хими цех	Химийн аппаратчин
8.	Тэргүүний ээлжийн мастер	Б.Ренчинханд	Цахилгаан цех	Ээлжийн мастер
9.	Тэргүүний албан хаагч	Э.Энхцэцэг	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн
10.	Тэргүүний ИТА	Г.Нямбат	Компьютер-ДХА цех	Компьютер удирдлага, программ хангамжийн инженер
11.	Бүтээлч ажилтан	А.Мөнхбаатар	Цахилгаан шугам сүлжээний цех	Гагнуурчин
12.	Шилдэг ажилтан	С.Ганбаатар	Зуухан цех	Цехийн дарга

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний салбарын шилдэг байгууллага, менежер, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтан, бүтээн байгуулалтын ажлыг шалгаруулах журам, Эрчим хүчний сайдын 2025 оны А/68 дугаар тушаалаар байгуулсан Салбарын шилдэг шалгаруулах комиссын шийдвэрээр 2024 оны Эрчим хүчний салбарын шилдэг ажилтнаар Лувсангийн Эрдэнэхүү – “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийн турбин цехийн засварчин шалгарсан байна.



Дорнод аймгийн БТСГазраас “ДБЭХС” ТӨХК-ийг Нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хамт олны дунд зохиох арга хэмжээний нэр төрөл, тоог нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын бие бялдарын түвшинг дээшлүүлэхэд хамтран ажилласаныг үнэлэн “Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага”-аар шалгаруулж талархлын бичиг гардуулсан.

“ХАВРЫГ ХАМТДАА ДАВЦГААЯ” малчдад туслах аяны хүрээнд компанийн ажилтнуудыг уриалан 4,6 сая төгрөгийн мөнгөн тусламж, эд материал төвлөрүүлэн хамтран ажилладаг Булган сумын малчдад хүргүүлсэн.





Эрчим хүчнийхэн бид Эх орныхоо хөгжил, цэцэглэлтийн түүчээ болж, хэрэглэгчдийнхээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй хэрэглээг тасралтгүй, найдвартай хангахын төлөө, улс орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагатай үүргээ биелүүлж ирсэн түүхтэй билээ.

Эрчим хүчний салбарын баярын өдрийг 2024 оны 08 дугаар сарын 24 ны өдөр Баянтүмэн сумын талбайд тэмдэглэн өнгөрүүлэв.

Бөхийн барилдаан 32 бөх зодоглож үзүүр, түрүүнд Нийтлэг үйлчилгээний хэлтсийн 2 бөх тунан үлдэж залуу бөх Ж.Батхуяг давснаар 2024 оны Эрчим хүчний салбарын ажиллагсдын баярын өдрийн түрүү бөхөөр шалгарч даагаар шагнууллаа.



Сур харваанд эмэгтэй 17, эрэгтэй 20 нийт 37 харваачид оролцсоноос сумын мэргэн харваач 1, сумын гарамгай харваач 2, сумын гоц-1, залуу харваач 33 харваач оролцсон.

Эрэгтэй

1-р байранд Сүхбаатар ЦТСүлжээ салбарын Бичилтийн техникч У.Уртнасан,

2-р байранд ЭХБХ-ийн ТҮ-ний инженер Ц.Болдбаатар,

3-р байранд ЭХБХ-ийн Сумд хариуцсан инженер Ж.Энхтүвшин,

Эмэгтэй

1-р байранд Хими цехийн Химийн аппаратчин Д.Цэрэнханд,

2-р байранд ЭХБХ-ийн ХХАТ-ын ахлагч О.Батгэрэл,

3-р байранд Хими цехийн Түлш тосны лаборант Б.Цэрэннадмид



Эрчим хүчний салбарын “Спортын их наадам-2024” тэмцээн 05 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд Буянт-Ухаа, UG ARENA спорт цогцолбор, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Эрчим хүчний салбарын 31 байгууллагын 1300 гаруй тамирчин спортын 6 төрлөөр (сагсан бөмбөг, ширээний теннис, волейбол, шатар, орс таталт, и-спорт) хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн тус наадамд “ДБЭХС” ТӨХК-ийн баг тамирчид ОЛС ТАТАЛТ төрөлд хүрэл медаль хүртлээ.



Архив, албан бичиг хөтлөлт

Байгууллагын архив нь техникийн зураг схемийн байнга хадгалах 1480, удирдлагын байнга хадгалах 1082, 70-н жил хадгалах 434, түр хадгалах 1980 хадгаламжийн нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж холбогдох ажилтнуудыг мэдээллээр ханган, хадгаламжийн сангаас баримтыг бүртгэлээр олгон ажиллаж байна.

2024 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 88, түр хадгалах 181, 70-н жил хадгалах 13 хадгаламжийн нэгжийг алба, хэлтсийн ажилтнуудаас хүлээн авч нийт 282 хадгаламжийн нэгжээр компанийн архивт нөхөн бүрдүүлэлт хийж, бүртгэж, дугаарлаж, нягтруулагчтай шүүгээнд байрлуулсан.



Шагнал урамшуулал:

2024 онд Компанийн шилдэг, тэргүүний ажилтан, ахмадуудыг Төрийн одон медаль болон Эрчим хүчний салбарын шагналаар шагнуулах саналыг нэгтгэж Гүйцэтгэх захирлаар хянуулан давхардсан тоогоор 63 ажилтан, ахмадын тодорхойлолтыг бичиж холбогдох газарт явуулсан.

Төрийн одон медаль болон Эрчим хүчний салбар, аймаг, хотын шагналаар нийт 52 ажилтан, ахмад, спортын мастер цол тэмдгээр 1 ажилтан шагнагдсан. Үүнд:

- Алтан гадас одонгоор 1 ахмад, 1 ажилтан
- Хөдөлмөрийн хүндэт медалиар 2 ахмад, 4 ажилтан
- Эрчим хүчний Тэргүүний ажилтан цол, тэмдгээр 2 ажилтан
- Дорнод аймгийн Тэргүүний ажилтан цол, тэмдгээр 12 ажилтан
- Дорнод аймгийн Засаг даргын жуух бичгээр 14 ажилтан
- Чойбалсан хотын Тэргүүний ажилтан цол, тэмдгээр 9 ажилтан
- Чойбалсан хотын Засаг даргын Хүндэт жуух бичгээр 7 ажилтан
- Спортын дэд мастер цол, тэмдгээр 1 ажилтан

2024 онд ЭХТА-ны урамшуулалд 113 ажилтан, 186 ахмадад нийт 53,205,000 төгрөгийн төсөв зарцуулсан байна.



Компанийн ахмадууд:

2024 онд эрэгтэй 10, эмэгтэй 11 ажилтан тэтгэвэрт гарч, өргөдлөөр 1 ахмад нэмэгдэн нийт 22 ахмадыг бүртгэлд нэмсэн ба 9 ахмад нас барж хасагдсан.

Оны эцсийн байдлаар 298 ахмад бүртгэлтэй байна. Өмнөх онтой харьцуулахад ахмадын тоо 13-аар өссөн.

2024 онд 60, 70, 80, 90 насны ойн тэтгэмж авах 25 ахмадын судалгаа гаргаж холбогдох зардлыг төсөвт тусган ажилласан.

2024 онд Уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан нийт 292 ахмадад гарын бэлэг 55,555 төгрөг буюу нийт 16,2 сая төгрөг, халаалтын хөнгөлөлтөд 264 ахмадад 26,4 сая төгрөг тус тус зарцуулсан.

■ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэг.Хөрөнгө

Компанийн нийт хөрөнгө тайлант оны эцэст 376743.3 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 123556.4 сая.төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн дүнгийн 2.4 %-ийг эргэлтийн хөрөнгийн дүн, 97.6 %-ийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна.

А.Эргэлтийн хөрөнгө (сая.төг)

Д/д	Балансын зүйл	2023.12.31	2024.12.31	Өөрчлөлт	Нийт эргэлтийн хөрөнгийн дүнд эзлэх хувь
0	1	2	3	4	5
1	Мөнгө	247.4	505.6	258.2	5.5
2	Дансны авлага	1543.4	1583.2	39.8	17.2
3	НӨАТатвар	1391.5	1298.0	-93.5	14.1
4	Бусад авлага	108.8	124.4	15.6	1.4
5	Бараа материал	3199.7	5544.9	2345.2	60.2
6	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	31.9	22.3	-9.6	0.2
7	Бусад эргэлтийн хөрөнгө	216.8	126.9	-89.9	1.4
	Дүн	6739.6	9205.3	2465.7	100

Эргэлтийн хөрөнгийн дүнгийн өөрчлөлтөөс харахад нийт эргэлтийн хөрөнгийн хэмжээ оны эхний үлдэгдлээс 2465.7 сая төгрөгөөр өссөн бөгөөд мөнгөний үлдэгдэл 258.2 сая төгрөгөөр, дансны авлага /цахилгаан дулааны эрчим хүчний борлуулалтын авлага/ 39.8 сая төгрөгөөр, бусад авлага 15.6 сая төгрөгөөр, бараа материалын үлдэгдэл 2345.2 сая төгрөгөөр тус тус өсч, урьдчилж төлсөн зардал 9.6 сая төгрөгөөр, бусад эргэлтийн хөрөнгө буюу мал сүрэг 89.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Дээрх эргэлтийн хөрөнгөөс бараа материалын үлдэгдэл хамгийн их буюу 2345.2 сая төгрөгөөр өссөн гол үзүүлэлт нь тайлант оны 12-р сард нүүрс бэлтгэн нийлүүлэгч компаниудаас 138544.3 тонн нүүрс худалдан авсан бөгөөд нүүрсний талбайдаа 93509.79 тонн /мөнгөн дүнгээр 2952.9 сая төгрөг/ нүүрсний үлдэгдэлтэй дараагийн сард шилжсэн.

Д/д	Авлагын төрөл	2023.12.31	2024.12.31	Өөрчлөлт	Дүнд эзлэх хувь
0	1	2	3	4	5
1	Борлуулалтын авлага	1543.4	1583.2	39.8	52.7
2	Байгууллагаас авах авлага	91.6	111.6	20.0	3.7
3	Хувь хүмүүсээс авах авлага	0.0	11.6	11.6	0.3
4	Цалингийн авлага	17.2	1.0	-16.2	0.1
5	Татварын авлага НӨТ	1391.5	1298.2	-93.3	43.2
	Дүн	3043.7	3005.6	-38.1	100



- Компанийн нийт авлагын хувьд тайлант хугацаанд авлага 38.1 сая төгрөгөөр буурч 3005.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна.
- Авлагуудын дотор борлуулалтын авлага оны эхний үлдэгдлээс 39.8 сая төгрөгөөр өсч 1583.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байгаа бөгөөд 53.7 хувь буюу 850.5 сая төгрөг нь ААНБ-с авах авлага, 46.3 хувь буюу 732.7 сая төгрөг нь айл өрхөөс авах цахилгаан эрчим хүчний авлага байна.
- Байгууллагаас авах бусад авлагын хувьд оны эхний үлдэгдлээс 20.0 сая төгрөгөөр өсч 111.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна.Дээрх авлагын дүнгийн 106.3 сая төгрөг нь шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага.
- Хувь хүмүүсээс авах авлага оны эхний үлдэгдлээс 11.6 сая төгрөгөөр нэмэгдэж 11.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна.Энэ авлага нь 2 хүнтэй холбоотой авлага. / 7.2 сая төгрөг нь тус компанийн ачааг тээвэрлэж явсан жолоочийн машин шатсанаас үүссэн кабелийн үнийн үлдэгдэл дүн, 4.4 сая төгрөг нь Төслийн нэгжийн захирал Ц.Батсайханаас авах авлага/.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын авлагын үлдэгдэл 93.3 сая төгрөгөөр буурч 1298.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан. Энэ нь нэмэгдсэн өртгийн албан тухай хуулийн 14.1.5,14.1.5а,14.1.5б -д заасны дагуу хорогдуулалт хийгддэг.

- Томоохон авлагыг жагсаалтаар харуулбал: (сая.төг)

Д/д	Байгууллагын нэр	2023.12.31	2024.12.31	Зөрүү +/-	Тайлбар
1	ААНБ-с авах ЦДЭХ авлага	916.2	830.5	-85.7	Борлуулалтын авлага
2	Айл өрхөөс авах ЦЭХ авлага	617.9	732.7	114.8	Борлуулалтын авлага
3	Уул уурхайн компаниудаас авах ЦЭХ авлага	9.2	20.0	10.8	Борлуулалтын авлага
4	Жараахайн булаг ХХК	7.1	0.00	-7.2	Бусад авлага
5	Си ий ай эм ХХК	45.6	0.00	-45.6	Шүүхийн шийдвэрээр авлагыг хэрэгсэхгүй болгосон
6	ЭХЯам	35.5	106.3	70.8	Бусад авлага
	Дүн	1631.5	1689.5	58	

Б.Эргэлтийн бус хөрөнгө (сая.төг)

Д/д	Балансын зүйл	2023.12.31	Нэмэгдсэн	Хорогдсон	2024.12.31	Өөрчлөлт
0	1	2	3	4		5
1	Үндсэн хөрөнгө	385486.1	131382.8	4843.2	512025.7	
2	Хуримтлагдсан элэгдэл	-158119.8	-6857.7	-1470.8	-163506.7	
3	Биет бус хөрөнгө	19424.9	-	18.9	19406.0	
4	Биет бус хөрөнгийн элэгдэл	-344.0	-61.9	-18.9		
	Дүн	246447.2	124463.2	3372.4	367538.0	121090.8

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 131382.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэлд 6857.7 сая төгрөг байгуулсан байна. Тайлант хугацаанд дараах үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнд:

Д/д	Хөрөнгийн нэр	Дүн (Сая.төг)	Тайлбар
1	Дуусаагүй барилга	127671.3	2379.4 сая төгрөг нь их засвар, 125291.9 сая төгрөг төсөлтэй холбоотой капиталжих хөрөнгө
2	Барилга байгууламж	608.7	Халхгол сумын доторх ЦДАШугам-13 км үнэ 102.1 сая төгрөг /ТӨБЗГ-н шийдвэрээр/, 506.6 сая төгрөг нь их засвар
3	Машин тоног төхөөрөмж	2965.6	Худалдаж авсан хөрөнгө 364.0 сая төгрөг, 2601.7 сая төгрөг нь их засвар
4	Тээврийн хэрэгсэл	35.0	Худалдаж авсан
5	Тавилга эд хогшил	48.8	Худалдаж авсан
6	Компьютер бусад хэрэгсэл	53.3	Худалдаж авсан
	Дүн	131382.8	

Хоёр. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Тайлант оны эцэст компанийн нийт өр төлбөр 296280.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхний үлдэгдлээс 126078.5 сая төгрөгөөр өсч гарч байна.

А. Өр төлбөр (сая.төг)

Д/д	Балансын зүйл	2023.12.31	2024.12.31	Өөрчлөлт	Дүнд эзлэх хувь
0	1	2	3	4	5
1	Дансны өглөг	9311.7	21050.0	11738.3	74.7
2	Цалингийн өглөг	16.6	-	-16.6	-
3	Татварын өглөг	2196.8	4367.2	2170.4	15.5
4	НДШ-ийн өглөг	107.2	1.3	-105.9	0.1
5	Хүүний өглөг	1278.2	2632.1	1353.9	9.3
6	Урьдчилж орсон орлого	603.4	113.4	-490.0	0.4
	Богино хугацаат өр төбөрийн дүн	13513.9	28164.0	14650.1	100
1	Урт хугацаат зээл	114379.8	199417.9	85038.1	76.3
2	Хойшлогдсон орлого	42308.4	68698.7	26390.3	23.7
	Урт хугацаат өр төлбөр	156688.2	268116.6	111428.4	100
	Өр төлбөрийн нийт дүн	170202.1	296280.6	126078.5	

Дансны өглөг оны эхний үлдэгдлээс 11738.3 сая төгрөгөөр өсч 21050.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна. Дээрх өглөгийн 73 хувь буюу 15356.1 сая төгрөг нь Төвийн эрчим хүчний системээс худалдан авсан цахилгаан эрчим хүчний өглөг эзэлж байна. Мөн 25.0 хувь буюу 5245.0 сая төгрөг нь 12-р сард бэлтгэн нийлүүлэгч компаниудаас худалдан авсан нүүрсний үнийн өглөг./Гэрээний дагуу дараа сарын 15-ны дотор төлбөр хийгддэг/.



- **Цалингийн өглөгийн** хувьд цалингийн өрийн үлдэгдэлгүй гарсан байна.

- **Татварын өглөгийн** үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 2170.4 сая төгрөгөөр өсч 4367.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна. Дээрх татварын өрийн 84.0 хувь буюу 3666.8 сая төгрөг нь Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг, 12.8 хувь буюу 557.3 сая төгрөг нь хувь хүний орлогын албан татварын өглөг, үлдэгдэл өглөг нь суутган тооцсон татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өр байна.

- **Нийгмийн даатгалын** шимтгэлийн үлдэгдлийн хувьд тайлант оны эхний үлдэгдлээс 105.9 сая төгрөгөөр буурч 1.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

- **Хүүний өглөг** 2632.1 сая төгрөг нь МУ-ын хөгжлийн банкнаас авсан зээлийн хүүгийн 2024 оны 5-р сарын 30-ны өдөр хүртэлх хуримтлагдсан өрийг санхүүгийн тайланд бүртгэснээс үүссэн байна.

- **Урьдчилж орсон орлого**-н 66.2 сая төгрөг нь Эм эл цахиурт овоо ХХК-ийн урьдчилж төлсөн төлбөр, бусад нь жижиг ААНБ-ын цахилгаан эрчим хүчний урьдчилж төлсөн орлого байна.

-Урт хугацаат зээл:

Компанийн урт хугацаат зээлийн үлдэгдэл 2024 оны 12-р сарын 31-ны байдлаар 199417.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

-Дамжуулан зээлдүүлсний төлбөр / Германы сэргээн босголтын банк болон дэлхийн банк /

-9766031 тоот дамжуулан зээлдэх гэрээ /ХБНГУ/-ний зээлийн үлдэгдэл-2493.8 сая төг.

-9766031 А тоот дамжуулан зээлдэх гэрээ /ХБНГУ/-ны зээлийн үлдэгдэл-1462.3 сая төг

-3503-MOG тоот дамжуулан зээлдэх гэрээ /Дэлхийн банк/-ны зээлийн үлдэгдэл / Дорнод аймаг/-1240.0 сая төгрөг.

-3503-MOG тоот дамжуулан зээлдэх гэрээ /Дэлхийн банк/-ны зээлийн үлдэгдэл / Сүхбаатар аймаг/-321.7 сая төгрөг.

-МУ-ын хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээл:

-Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих “Чойбалсангийн ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-ын шингэ станцаар өргөтгөх” төслийн ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ЭХА -012/2019 тоот гэрээг 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр гүйцэтгэгч компани болох БНХАУ-ын ТБЕА ХХК-тай байгуулан ажиллаж байна.Төслийн нийт санхүүжилт 81.91 сая ам доллар ба үүний 60.0 сая ам долларыг МУ-ын хөгжлийн банкны зээлээр, 21.91 сая ам долларыг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. 2024 оны 12-р сарын 31-ны байдлаар зээлийн үлдэгдэл 191814.0 сая төгрөг байна.

-2021 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан ЗГ-ДБ-З 2021-17 дугаартай зээлийн Хавсралт-т заагдсан Засгийн газрын өрийн баталгааны шимтгэл /Зээлийн дүн 2266145070.37 төгрөг/ төлөх урт хугацаат зээл:

-Хойшлогдсон орлого:

-Хойшлогдсон орлогын үлдэгдэл тайлант оны эцэст 68698.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхний үлдэгдлээс 26390.3 сая төгрөгөөр өссөн байна.Энэ өсөлт нь “Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-ын шинэ станцаар өргөтгөх” төслийг гүйцэтгэгч ТБЕА ХХК-д 9,10-р гүйцэтгэлд 26584.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын элэгдлийн зардал болох 194.4 сая төгрөгийг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан.

Б.Эзэмшигчдын өмч (сая.төг)

Д/д	Балансын зүйл	2023.12.31	Нэмэгдсэн	Хорогдсон	2024.12.31
1	Эзэмшигчдын өмч	82984.7	102.1	2624.2	80462.6
2	Дүн				

- Эзэмшигчдийн өмчийн хувьд 102.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 2023 оны ноогдол ашигт 731.8 сая төгрөг олгохоор тооцож, мөн тайлант хугацаанд 1892.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаар эзэмшигчийн өмчийн дүн 80462.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна.

Гурав.Орлого үр дүн

- Тайлант хугацаанд 85955.4 сая төгрөгийн орлоготой, 87847.8 сая төгрөгийн зардал гаргаж 1892.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Дөрөв.Бусад

-Тайлант хугацаанд компани улс орон нутгийн төсөвт татвараар болон нийгмийн даатгалын шимтгэлд нийт 12345.6 сая төгрөг төлсөн байна.

2024 онд улс орон нутгийн төсөвт дараах татварыг төлсөн байна.

Үүнд

№	Татварын төрөл	2021 онд төлсөн татвар	2022 онд төлсөн татвар	2023 онд төлсөн татвар	2024 онд төлсөн татвар	Дүн
1	ААНОАТатвар	15.67	46.18	51.11	461.9	574.86
2	НӨАТатвар	2764.41	1798.09	3299.24	1349.7	9211.44
3	НДШимтгэл	4029.26	4343.03	5529.09	7265.5	21166.88
4	ХХОАТатвар	1254.30	1103.50	1694.64	2443.9	6496.34
5	ҮХХАТатвар	105.24	265.13	348.44	350.5	1069.31
6	Газрын төлбөр	36.45	74.49	179.10	179.2	469.24
7	Усны НАТатвар	152.72	141.72	124.78	133.4	552.62
8	АТБӨЯХТ, Агаарын бохирдол	1.93	1.94	1.88	2.5	8.25
9	Суутган	4.91	4.97	5.40	15.0	30.28
10	Агаарын бохирдлын төлбөр	37.62	37.85	-	128.6	204.07
11	Ус бохирдуулсны төлбөр	8.51	6.05	-	10.4	24.96
12	Малын татвар	-	-	0.92	0.3	1.22
13	Бусад татвар	-	-	-	4.7	4.7
	НИЙТ ДҮН	8411.02	7822.95	11234.6	12345.6	39814.17



“ДБЭХС” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ: (сая.төг)

№	ҮЗҮҮЛЭЛТ	ШИНЖИЛГЭЭНИЙ ТОМЪЁО	2023 он		2024 он		Тайлбар
1. Ашигт ажиллагааны шинжилгээ							
1.1	Борлуулалтын ашигт ажиллагаа	Нийт ашиг	22,346.80	34%	16,423.46	22%	Борлуулалтаас тооцсон нэмэгдлийн хувь (их байвал сайн)
		Борлуулалтын орлого	66,502.66		75,118.77		
1.2	Өртгөөр тооцсон ашигт ажиллагаа	Нийт ашиг	22,346.80	51%	16,423.46	28%	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгөөс тооцсон нэмэгдлийн хувь (их байвал сайн)
		ББӨртөг	44,155.85		58,695.31		
1.3	Хөрөнгийн ашигт ажиллагаа	Цэвэр ашиг	4,879.14	1.9%	(1,892.39)	-0.5%	Тухайн компанийн балансын хөрөнгийн ашигт ажиллагааны түвшинг харуулна (их байвал сайн)
		Балансын дүн	253,186.84		376,743.26		
1.4	Өөрийн капиталын ашигт ажиллагаа	Цэвэр ашиг	4,879.14	5.9%	(1,892.39)	-2.4%	Компаний өөрийн цэвэр хөрөнгө оруулалтын ашигт ажиллагааны түвшинг харуулна (их байвал сайн)
		Өөрийн капитал	82,984.76		80,462.60		
2. Төлбөрийн чадварын шинжилгээ							
2.1	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Мөнгөн хөрөнгө	247.40	2%	505.61	2%	Бэлэн мөнгөөр өр төлбөрийнхөө хэдэн хувийг барагдуулж чадах (их байвал сайн)
		Богино хугацаат өр төлбөр	13,513.86		28,164.03		
2.2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Мөнгөн хөрөнгө+Авлага	3,291.13	0.24	3,511.17	0.12	Авлагаа цуглуулаад өр төлбөрийнхөө хэд дахин төлж чадах чадварыг харуулна. (их байвал маш сайн)
		Богино хугацаат өр төлбөр	13,513.86		28,164.03		
2.3	Эргэлтийн харьцаа	Нийт эргэлтийн хөрөнгө	6,739.60	0.50	9,205.28	0.33	Нийт эрэгэлтийн хөрөнгөөрөө өр төлбөрөө хэд дахин төлж чадах чадварыг харуулна. (1.5-аас их байвал маш сайн)
		Богино хугацаат өр төлбөр	13,513.86		28,164.03		
2.4	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	Нийт эргэлтийн хөрөнгө	6,739.60	3%	9,205.28	2%	Нийт хөрөнгийн үр ашигтай ашиглалтыг харуулсан үзүүлэлт их байх тусмаа сайн.
		Балансын цэвэр дүн	253,186.84		376,743.26		
3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ							
3.1	Бие даах чадварын коэффициент	Өөрийн хөрөнгө	82,984.76	33%	80,462.60	21%	Балансанд өөрийн хөрөнгийн эзлэх хувийг харуулна. 50 хувиас их байлгах
		Балансын цэвэр дүн	253,186.84		376,743.26		
3.2	Гадны хөрөнгийн хувийн жин	Гадны хөрөнгө	170,202.08	67%	296,280.66	79%	Балансанд гадны хөрөнгийн эзлэх хувийг харуулна. 50 хувиас бага байлгах
		Балансын цэвэр дүн	253,186.84		376,743.26		
3.3	Гадны ба өөрийн хөрөнгийн харьцаа	Гадны хөрөнгө	170,202.08	205%	296,280.66	368%	Гадны хөрөнгө болон өөрийн хөрөнгө харьцаа 100 хувиас ихгүй байх
		Өөрийн хөрөнгө	82,984.76		80,462.60		
4. Эргэцийн шинжилгээ							
4.1	Авлага цуглуулах дундаж хугацаа	Авлага*360хоног	555,613.20	8.35	569,941.20	7.59	"Дансны авлага үүсч бий болоод төлөгдөж орж ирэх хүртэлх хугацаа бага байвал сайн/"
		Борлуулалтын орлого	66,502.66		75,118.77		
4.2	Төлбөр төлөх дундаж хугацаа	Дансны өр*360 хоног	3,352,210.20	111.45	7,578,000.00	297.21	Дансны өрөө дунджаар хэд хоногт барагдуулж байгааг харуулна. Бага байвал сайн.
		Худалдан авалт	30,077.29		25,496.73		
4.3	Бараа материалын эргэц	ББӨ	44,155.85	13.80	58,695.31	10.59	Бараа материалын дундаж наслалтыг харуулна.
		Бараа материалын нөөц	3,199.74		5,544.93		
5. Бүтээмжийн шинжилгээ							
5.1	"Борлуулалтын ашигт ажиллагаа"	Цэвэр ашиг	4,879.14	7.3%	(1,892.39)	-2.5%	"1 төгрөгийн борлуулалтын орлогоос олж байгаа ашгийн түвшинг илэрхийлнэ."
		Борлуулалтын орлого	66,502.66		75,118.77		
5.2	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	Борлуулалтын орлого	66,502.66	150.6%	75,118.77	128.0%	Ахиуц нийт ашиг нь өндөр байвал ББӨ бага, бага байвал ББӨ өндөр байгааг илэрхийлдэг.
		ББӨртөг	44,155.85		58,695.31		
5.3	"Хөрөнгийн ашигт ажиллагаа"	Цэвэр ашиг	4,879.14	1.9%	(1,892.39)	-0.5%	"Эздийн өмчийн 1 төгрөг тутамд ногдож буй цэвэр ашгийн хэмжээ буюу өмчийг хэрхэн үр ашигтай ашиглаж байгааг илэрхийлнэ."
		Нийт хөрөнгө	253,186.84		376,743.26		
5.4	"Өөрийн капиталын ашигт ажиллагаа"	Цэвэр ашиг	4,879.14	5.9%	(1,892.39)	-2.4%	
		Өөрийн капитал	82,984.76		80,462.60		

ДБЗХС ТӨХХ-ийн
2024 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн
Бодит байдлын тухай мэдэгдэл

2024 оны 12 сарын 31 ны өдөр

Гүйцэтгэх захирал Б.Жаргалсайхан, Ерөнхий нягтлан бодогч Б.Энхбаатар бид манай аж ахуйн нэгжийн 2024 оны С9 дугаар сарын 30 ны өдөрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант дугаарыг үлгэрлэсний үр дүн, санхүүгийн байдлыг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 17.1 дэх хялбарын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан бэлжжиг бэлтгэж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитой гэрсэн бөгөөд холбогдох анхан шатны баримтын үндэстэн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн хийгдсэн.
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
4. Тайлант үеийн үр дүнд нэмэх оны ажил гүйлгээнээс шилжлэг тусгагдсаныг, мөн тайлант оны ажил гүйлгээнээс оржигдсон зүйл бэйлгүй.
5. Бүх хөрөнгө, өрлөг, өр төлбөр, ослоро, зардлыг Санхүүгийн тайлагнеллын олон улсын стандуудын дагуу үнэн зөв тусгасан.
6. Энх тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан соны өмчлөлд байдаг бөгөөд оржигдсон зүйл үгүй болно.

Гүйцэтгэх захирал

Ерөнхий нягтлан бодогч



(Б.ЖАРГАЛСАЙХАН)

(Б.ЭНХБААТАР)



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ДБХХС ТӨХК

2024 оны 12 сарын 31 ны өдөр

/Аж ахуй нэгж, байгууллагын нэр/

/төгрөгөөр/

Мерийн дугаар	ҮЗҮҮГ ЭЛТ	Тайлант үс	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ	*	*
1.10	Эргэлтийн хөрөнгө	*	*
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	247,358,223.51	505,310,115.82
1.1.2	Дансны аяллага	1,543,372,328.37	1,583,179,461.33
1.1.3	Гэтвэр, НДС-ийн аяллага	1,081,527,240.70	1,297,863,130.95
1.1.4	Бусад аяллага	108,832,319.35	124,417,609.14
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Барьцаа материал	5,199,738,852.67	5,644,533,928.53
1.1.7	Урьдчилж төлсөн зэрдэг/тооцоо	31,913,523.47	22,289,502.50
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	216,319,000.00	125,867,500.00
1.1.9	Борлуулах зорилгоор зэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,739,801,586.77	9,205,280,268.27
1.20	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	227,366,318,025.82	343,515,986,848.55
1.2.2	Емэт бус хөрөнгө	19,080,518,248.65	19,010,937,208.35
1.2.3	Лусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуур ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зохицуулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	245,447,236,274.51	367,537,984,057.50
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	253,185,837,862.78	376,743,264,345.77
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.10	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,511,655,416.14	21,050,004,677.67
2.1.1.2	Цэлингийн өглөг	16,534,020.13	-
2.1.1.3	Татварын өр	2,196,840,146.18	4,367,203,056.70
2.1.1.4	НДС-ийн өглөг	107,150,635.19	1,285,409.04
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	1,278,138,317.53	2,652,125,047.20
2.1.1.7	Нэгдэл ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж өссөн орлого	603,391,974.19	113,412,128.55
2.1.1.9	Нөөцлөх төлбөр		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.11			
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,513,860,410.16	28,164,037,618.16
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	урт хугацаат зээл	114,378,788,915.15	193,417,924,298.50
2.1.2.2	төөлөх өр төлбөр		

2.1.2.3	Хайшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Хайшлогдсон өр нийт	42,308,425,597.44	68,698,699,283.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	156,688,214,012.59	268,116,623,582.25
2.20	Өр төлбөрийн нийт дүн	170,202,076,022.75	296,280,661,200.41
2.30	Эздийн өмч		
2.3.1	Гя+ -терийн	51,590,219,512.43	51,590,219,512.43
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халдасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,111,700,363.84	11,106,873,703.96
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,325,030,500.68	18,427,130,553.03
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,957,612,493.06	-667,620,703.16
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	82,984,762,840.03	80,452,603,145.36
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	253,186,837,862.78	376,743,264,345.77

Гүйцэтгэх захирал

(Б.ХАРАГДАСАЙХАН)

Ерөнхий нягтлан бодогч

(Б.ЭНХБААТАР)





ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ДБЭХС ТӨХК

(ДХ зүй нэгж, бэй уулзалтын нэр)

2024 оны 12 сарын 31 ны өдөр

/ газрагаар /

Мэрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 -р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (нээвэр)	65,602,657,073.36	75,118,772,208.88
2	Борлуулалтын өртөг	44,155,853,157.11	58,605,307,902.21
3	Нийт ашиг/алдагдал/	22,346,803,921.75	16,423,464,304.65
4	Түрээсийн орлого	32,057,097.84	35,063,606.10
5	Хүчний орлого	11,051,397.93	45,404,846.77
6	Нэгдүгээний орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,688,188,824.60	8,075,051,337.37
9	Борлуулалт, маркетингийн зардал	12,240,707,060.38	14,873,484,590.13
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,954,848,650.34	4,075,304,814.15
11	Санхүүгийн зардал	67,771,125.12	6,135,127,774.22
12	Бусад зардал	3,814,652,677.63	4,125,667,080.63
13	Гадаад валютын ханшийн эвлүүлний олз (гарз)	350,902,536.35	2,675,658,830.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Бичиг бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар толохгүй өмнөх ашиг (алдагдал)	5,391,054,768.08	-1,755,991,314.34
19	Орлогын татварын зардал	5,118,13,563.20	196,397,253.44
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,879,141,194.88	-1,892,388,567.78
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,879,141,194.88	-1,892,388,567.78
23	Бусад дэлгэрэнгүй орлого		-
23.1	Хэрэнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зарцуу		-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зарцуу		-
23.3	Бусад олз (гарз)		-
24	Орлогын нийт дүн	4,879,141,194.88	-1,892,388,567.78
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Гүйцэтгэх захирал

Ерөнхий-ялгавар бодлогч



(Б.ЖАРГАЛСАЙХАНИ)

(Б.ЭНХБААТАР)

ЦЕЭХС ТӨХК

Удгэрхгүй үйлдэл, бэртүүлэгч - эрх

2024-04-12 08:31:43

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хягагчийн хувьцаа	Нэмж тусгасны капитал	Хэрэг гүйцэх үйлдвэрлэлийн нэмэгдэл	Гэдвэд валютын хөрвүүлэлтийн коэффициент	Зөвлөх өмчийн бүсэд хэсэг	Хуримтлагдсан ашиг	Илт дүн
1	2022 оны 12 дугаар сарын 31 үндэслэн	51,370,219,512.43	0.00	0.00	11,132,551,592.91	0.00	18,545,000,500.65	-2,042,172,238.62	78,125,620,077.40
2	Пайсан босох бүртгэлийн борлогчийн өмчлөлтөд өртөг, алдааныг зогсоулах								0.00
3	Загваруулсан үйлдвэрлэл								0.00
4	Тойрогт үеийн - цэвэр ашиг (алдагдал)							4,879,111,791.88	-3,981,777,597.88
5	Бүтэцлэлт, эзэнгүй эрхлөгч								0.00
6	Өмчлөлд гарсан өөрчлөлт	220,300,000.00					-220,300,000.00	-7,432.25	0.00
7	Зарласан - юрдал ашиг								-7,432.25
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хөрөнгө дүн							20,850,959.07	0.00
9	2023 оны 12 дугаар сарын 31 үндэслэн	51,360,219,512.43	0.00	0.00	11,111,700,350.84	0.00	15,325,030,500.65	1,057,812,453.08	82,964,752,840.03
10	-ялга босох бүртгэлийн борлогчийн өмчлөлтөд өртөг, алдааныг зогсоулах								0.00
11	Загваруулсан үйлдвэрлэл								0.00
12	Тойрогт үеийн - цэвэр ашиг (алдагдал)							-1,892,348,267.78	-1,892,348,267.78
13	Бүтэцлэлт, эзэнгүй эрхлөгч						102,100,052.35		102,100,052.35
14	Өмчлөлд гарсан өөрчлөлт								0.00
15	Зарласан - ноцол ашиг							731,871,179.24	-731,871,179.24
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хөрөнгө дүн							4,826,579.03	0.00
17	2024 оны 12 дугаар сарын 31 үндэслэн	51,580,219,712.43	0.00	0.00	11,150,073,700.00	0.00	10,427,100,593.00	-901,020,703.95	80,452,603,145.35

Директор ООО "ИП" *И.И. Иванов*



МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАГ

ДБАХС ТӨХК

Ихэнх хуульчилж, байгууллагын нэр

2024 оны 12 сарын 31 ны өдөр

төгрөгөөс

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны монгол гүйлгээ		
1.1	Монгол орлогын дүн (+)	73,380,881,451.97	88,905,916,895.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	71,704,403,091.13	87,282,387,914.42
1.1.2	Эрхийн шилтгэл, хуримж, тн бичгийн орлого		
1.1.3	Датгалын нөхөрсөөс хүлээн авсан мөнгө	31,517,713.00	1,432,512.00
1.1.4	Буцаан авсан алба- төтөөр		
1.1.5	Тэтгээс, санхүүжилтийн орлого		5,791,100,000.00
1.1.6	Бусад монгол орлого	1,594,958,544.84	2,831,893,269.41
1.2	Монгол зарлагын дүн (-)	85,335,147,533.05	75,171,491,180.50
1.2.1	Ажилчдад төлсөн	18,480,331,251.27	24,161,555,820.94
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,529,082,533.24	7,265,481,290.00
1.2.3	Бараа материал худалдан авлахад төлсөн	16,057,957,542.30	7,905,723,760.77
1.2.4	Ажиллагчийн зарцалд төлсөн	36,745,415.73	
1.2.5	Түлш, аятахуун, тээврийн хяналт, сандал хэрэгсэлд төлсөн	14,029,336,115.36	17,591,017,331.75
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,958,171,535.20	8,204,473,549.74
1.2.7	Төтөөр, байгууллагад төлсөн	5,705,515,254.11	5,000,193,792.37
1.2.8	Датгалын төлбөрт төлсөн	189,931,832.40	123,525,266.65
1.2.9	Бусад монгол зарлага	2,358,069,350.54	4,831,169,348.85
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр монгол гүйлгээний дүн	8,045,733,318.32	13,735,425,535.33
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны монгол гүйлгээ		
2.1	Монгол орлогын дүн (+)	25,444,762.32	51,374,348.40
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	14,375,000.00	5,988,500.00
2.1.2	Биет бүс хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бүтэц, олгосон зээл, монгол урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан гүүний орлого	11,060,762.32	45,405,848.40
2.1.7	Хүлээн авсан нэгдөл шилт		
2.1.8			
2.2	Монгол зарлагын дүн (-)	81,126,732,734.93	95,507,451,449.17
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	4,930,929,045.51	4,336,001,295.11
2.2.2	Биет бүс хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	737,571,946.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	75,458,231,733.42	80,915,450,154.06
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
2.2.5	Бүтэцэд олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр монгол гүйлгээ	-81,101,287,972.61	-95,256,077,100.77
3	Санхүүгийн үйл ажиллагааны монгол гүйлгээний дүн		
3.1	Монгол орлогын дүн (+)	74,373,557,534.42	90,919,450,164.06
3.1.1	Зээл авсан, өмчийн үнэт цаас, албанцаар хүлээн авсан	74,373,557,534.42	90,919,450,164.06
3.1.2	Хувьцаа болон өмчийн бүтэц, үнэт цаас гар ажиллагаа хийсэн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандиа	-	-
3.1.4	Валютын ханшийн ашиг	0.00	
3.2	Монгол зарлагын дүн (-)	1,559,627,795.56	9,140,585,695.31
3.2.1	Зээл, өмчийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,534,933,679.80	8,259,301,752.58
3.2.2	Санхүүгийн туслахын өглөгт төлсөн	24,626,633.91	109,414,353.39
3.2.3	Хувьцаа буцаан авчгаар авсан		
3.2.4	Төлсөн нэгдөл шилт	7,432.25	731,871,173.24
3.2.5	Валютын ханшийн алдагдал		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр монгол гүйлгээний	72,813,929,738.86	81,778,833,457.75
4	Бүх цэвэр монгол гүйлгээ	-241,624,315.23	256,211,692.31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	489,022,536.74	247,398,223.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	247,398,223.51	505,610,115.32

Гүйцэтгэх захирал

Ерөнхий нягтлан бодогч

(Б.ЖАРГАЛСАРХАН)

(Б.ЭНХБААТАР)


ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024 онд системийн хэмжээнд нийт 371,9 сая.кВт.ц ЦЭХ боловсруулж, төлөвлөгөөнөөс 5,2 сая буюу 1,43% иар, 330,9 сая.кВт.ц ЦЭХ түгээж, төлөвлөгөөнөөс 8,6 сая буюу 2,68% иар, өнгөрсөн онтой харьцуулахад нийт түгээлт 34,8 сая.кВт.ц буюу 11,8% иар өссөн байна.

Дорнод, Сүхбаатар аймгийн 39 сум, суурин газар болон 17 уул уурхай, газрын тосны хэрэглэгчдийг 330,8 сая.кВт.ц ЦЭХ-ээр хангаж, энэ нь төлөвлөгөөнөөс 2,7 %-иар, өнгөрсөн оноос 11,8 %-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ДЦС-ын хэмжээнд 296,1 сая.кВт.ц ЦЭХ боловсруулж, төлөвлөгөөнөөс 41,1 сая. кВт.ц буюу 12,2% иар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 47,2 сая буюу 19,0% иар өссөн, 254,9 сая.кВт.ц ЦЭХ түгээж, төлөвлөгөөнөөс 37,9 сая.кВт.ц буюу 12,9% иар буурч, өнгөрсөн оноос 38,9 сая.кВт.ц буюу 18,0% иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн 348780 ГКал ДЭХ түгээж, төлөвлөгөөнөөс 23090 ГКал буюу 7,1%-иар, 2023 онтой харьцуулахад 5,5%-иар өссөн байна.


Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Харьцуулалт			
				Өнгөрсөн оны мөн үетэй		Энэ оны төл-тэй	
		Төл	Гүйц	Биет	Хувь	Биет	Хувь
Боловсруулсан ЦЭХ	248,852.739	337,150.0	296,069.810	47,217.071	119.0	(41,080.19)	87.8
ДХЦЭХ	32,811.026	44,520.0	41,126.447	8,315.421		(3,393.553)	
Биет							
Хувь	13.18	13.20	13.89		0.71		0.69
Түгээсэн ЦЭХ	216,041.713	292,630.0	254,943.363	38,901.650	118.0	(37,686.64)	87.1
Түгээсэн ДЭХ	330.7	325.7	348.8	18.086	105.5	23.090	107.1




Энэ онд 50 МВт станц ашиглалтанд орсонтой холбоотой цахилгааны дээд ачаалал 76,0 МВт хүрч, доод ачаалал зуны ачааллын горимд 16,8 МВт байна.




Боловсруулсан ЦЭХ /сая.кВт.ц/



Түгээсэн ЦЭХ /сая.кВт.ц/



Түгээсэн ДЭХ /мян.ГКал/




Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч:

ДХЦЭХ-ийг 13,2 %-иар төлөвлөж, ЭХЗХороогоор батлуулан мөрдөж ажилласан ба гүйцэтгэлээр 41126,4 мян.кВт.ц буюу 13,89%-иар биелж, төлөвлөснөөс 0,69 пунктээр, өнгөрсөн оноос 0,71 пунктээр өссөн ба ЦЭХ-ний хэрэглээ төлөвлөснөөс 3393,5 мян. кВт.ц-аар буурсан.

ДХЦЭХ-ний өсөлтөнд:

- 50 МВт ын станцын ашиглалтанд орох хугацааны хэтрэлт болон нүүрсний нөөц бүрдүүлэлтээс шалтгаалсан ЦЭХ-ний хэрэглээний бууралт нь голлон нөлөөлсөн.
- Мөн 50 МВт станцын туршилтын хугацаанд 36 МВт станц дээр найдвартай ажиллагааг хангах үүднээс илүү тоноглол ажиллаж байсан.
- 2 станц зэрэг ажиллах хугацаанд уул уурхайн хэрэглээг дийлэнхдээ 50 МВт станц дээр авч байсан тул 36 МВт станцын ачаалал шөнийн цагт нэлээдгүй буурч байгаа тул ачааллын зөрүүгийн нөлөөгөөр ДХЦЭХ-ний эзлэх хувь өсөх хандлагатай байна.


Дотоод хэрэгцээний ЦЭХ /хувь/



2024 онд жишмэл түлшний хувийн зарцуулалт ЦЭХ-нд 550,4 гр/кВт.ц, ДЭХ-нд 191,1 кг/ГКал гарсан ба энэ нь төлөвлөснөөс ЦЭХ-нд 81,8 гр/кВт.ц, ДЭХ-нд 1,5 кг/ГКал-аар буурсан бол өмнөх онтой харьцуулахад ЦЭХ-нд 60,8 гр/кВт.ц, ДЭХ-нд 0,7 кг/ГКал-аар өссөн.

Түлшний хувийн зарцуулалтын бууралт нь 50 МВт станцын тоноглолын үзүүлэлт, ажиллагааны үе дэх параметрууд, уурын хувийн зарцуулалт зэрэг нь проектын өгөгдлүүд тодорхой бус байсан тул түлшний хувийн зарцуулалтыг 36 МВт станцын ТЭЗҮ-ийн аргачлалаар төлөвлөсөнтэй холбоотой. 50 МВт станцын ажилласан саруудад ТХЗарцуулалт төлөвлөснөөс эрс буурч гарсан.

Түлшний хувийн зарцуулалт





КОМПАНИЙН 2024 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 он			Төлөвлөгөөтэй	
				анх.төл	тод.төл	гүйц	тод.төл-с	хувиар
1	ЦЭХ боловсруулалт		сая. кВтц	337.2	288.2	296.07	7.9	102.7%
2	ДХЦЭХ	хувь	хувь	13.2%	13.8%	13.9%	0.05%	99.6%
		биет	сая. кВтц	44.52	39.87	41.13	1.3	96.9%
3	Нийт түгээх ЦЭХ		сая. кВтц	322.1	324.2	330.8	6.6	102.0%
	Үүнээс:	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	292.6	248.3	254.9	6.7	102.7%
		ХАЦЭХ-ДҮТ	сая. кВтц	29.3	75.6	75.5	- 0.08	99.9%
		Импортын ЦЭХ	сая. кВтц	0.256	0.335	0.337	0.0	100.5%
4	Түгээх ДЭХ		мян.Гкал	325.7	344.0	348.8	4.8	101.4%
5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	хувь	4.6%	6.6%	7.9%	1.3%	84.0%
		биет	сая. кВтц	14.83	21.38	25.97	4.59	82.3%
6	Нийт орлого		сая.төг	76,693.7	83,778.8	85,955.4	2,176.6	102.6%
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	75,715.4	76,750.0	75,118.8	- 1,631.20	97.9%
		Бусад орлого	сая.төг	978.3	978.3	4,461.3	3,483.03	456.0%
		50 мВт ТХН-ийн санхүүжилт	сая.төг	-	785.9	1,107.4	321.50	140.0%
		Татаас	сая.төг	-	5,264.6	5,267.9	3.300	100.1%
7	Нийт зардал		сая.төг	78,829.2	91,601.4	87,711.4	- 3,890.1	104.4%
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	75,515.8	74,998.5	70,362.4	- 4,636.1	106.6%
		ХАЦЭХ-ний зардал	сая.төг	2,601.1	15,229.7	15,140.5	- 89.2	100.6%
		Бусад зардал		712.3	712.3	1,501.3	789.0	47.4%
		50 мВт ТХН-ийн санхүүжилт	сая.төг	-	661.0	707.2	46.2	93.5%
8	Татвар төлөхийн өмнөх ашиг, / алдагдал/		сая.төг	(2,135.6)	(7,822.7)	(1,756.0)	6,066.7	445.5%
9	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал /		сая.төг	(2,135.6)	(7,822.7)	(1,892.4)	5,930.3	413.4%
10	БО-ын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.028	1.093	1.020	- 0.07	107.1%
11	Нийт авлага		сая.төг	3,415.0	3,278.0	3,005.6	- 272.4	109.1%
	Үүнээс:	ЭХ-ний авлага	сая.төг	1,758.0	1,650.0	1,583.2	- 66.8	104.2%
		Бусад	сая.төг	1,657.0	1,628.0	1,422.4	- 205.6	114.5%
12	Нийт өглөг		сая.төг	211,705.2	234,057.4	227,581.9	- 6,475.5	102.8%
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	204,370.2	207,562.2	202,050.0	- 5,512.2	102.7%
		БХӨТ	сая.төг	7,335.0	26,495.2	25,531.9	- 963.3	103.8%
13	Нийт ажилтан		тоо	620.0	737.0	673.0	- 64.0	109.5%
14	Нийт цалингийн сан		сая.төг	25,975	26,826	26,667	- 158.6	100.6%
15	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	3,779.24	3,363.58	3,093.43	- 270.2	96.4%
16	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВтц	632.22	565.00	550.38	-14.6	102.7%
		ДЭХ	кг/Гкал	192.56	191.40	191.08	-0.3	100.2%

“ДБЭХС” ТӨХК 2024 онд Монгол улсын зүүн бүсэд орших Дорнод, Сүхбаатар аймгийн 39 сум, суурин газарт нийт 36,507 хэрэглэгчийг 740 ажилтантайгаар цахилгаан, дулаан үйлдвэрлэх, цахилгаан, дулаан түгээх, цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах, цахилгаан импортлох үйл ажиллагааг найдвартай биелүүлж ажиллалаа.

2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин нь Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн а/17 дугаар тушаалаар батлагдсан. “Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төслийг 2024 оны 05 дугаар сарын 1-нээс ашиглалтанд оруулах хугацаа хойшилсонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 29 дугаар тогтоолоор, Эрчим хүчний сайдын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн а/307 дугаар тушаалаараа тодотгосон 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нэмэлтээр тодотгож баталсан.

Тус компанийн 2024 оны үйлдвэрлэл, борлуулалт, эдийн засаг, санхүүгийн байдлын талаар тайлбарыг тайлант оны гүйцэтгэл болон өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулан танилцуулж байна.

Цахилгааны жилийн дундаж ачаалал 33.7 МВт хүрч, өмнөх оноос 5.3 МВт-аар өссөн ба дээд ачаалал 2024 онд 76.0 МВт хүрч ажилласан.

Тайлант хугацаанд 288.16 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулахаас 296.1 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулж төлөвлөгөөг 102.7%-иар биелүүлж ажилласан. Цахилгаан эрчим хүчний боловсруулалт 7.91 сая.кВт.ц-аар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.22 сая.кВт.ц-аар нэмэгдсэн байна

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он	2024 он		өсөлт (+)бууралт (-)	
				Тод.төл	Гүйц	2023-с	тод.төл-с
1	Боловсруулалт	сая.кВтц	248.85	288.16	296.07	47.22	7.91
2	ДХЦЭХ	хувь	13.18%	13.84%	13.89%	0.71%	0.05%
		сая.кВтц	32.81	39.87	41.13	8.32	1.26
3	ЦЭХ түгээлт	сая.кВтц	295.98	324.21	330.76	34.78	6.55
4	ДЭХ түгээлт	мян.Гкал	330.69	348.40	348.78	18.09	0.38
5	ЖТХЗарцуулалт						
	Цахилгаанд	гр/кВтц	611.20	565.00	550.38	(60.82)	(14.6)
	Дулаанд	кг/Гкал	191.75	191.40	191.08	(0.67)	(0.3)

Боловсруулсан цахилгаан эрчим хүчний харьцуулалт (мян.кВт.ц)

Он	Сарууд	2024
2023 он	төлөвлөгөө	241,820.00
	гүйцэтгэл	246,438.52
2024 он	2024 төлөвлөгөө	288,160.00
	2024 төл/2023 гүйц-тэй харь +/-	41,721.48
	2024 төл/2023 гүйц-тэй харь %	17%
	2024 гүйцэтгэл	296,069.77
	өмнөх оноос +/-	49,631.25
	өмнөх оноос %	20%
	2024 гүйц/2024 төл-тэй харь +/-	7,909.77
	2024 гүйц/2024 төл-тэй харь %	3%



Цахилгаан эрчим хүчний хэрэглээний 32.9 хувийг Дорнод аймгийн аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, 21.0 хувийг Сүхбаатар аймаг, 46.1 хувийг уул уурхай, ашигт малтмал, газрын тосны аж ахуйн нэгжүүд эзэлж байна.

